

Монгол Улсын ОУИТБС-ын ажлын 5-р хэсэгт оруулж байгаа санал

Манай ажлын хэсэг нь Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд хууль жигд ялгаваргүй үйлчлэх болон АМНАТ, жишиг үнийн асуудлыг ойлгомжтой болгох асуудлаар судалгаа хийж байгаа болохоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ын жишээн дээр доорх саналыг хүргүүлж байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2014 онд 26,1 сая тонн хүдэр боловсруулан 516 мянган тонн зэсийн баяжмал, 4053 тонн молибденийн баяжмал үйлдвэрлэн борлуулж, үйлдвэрлэл, эдийн засгийн төлөвлөгөөт даалгавараа бүх үзүүлэлтээр бүрэн биелүүлж нийтдээ 167,5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хэдийгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК н жил бүр ашигтай ажиллах Улсын болон орон нутгийн төсөвт 2011 онд 555,4 тэрбум төгрөг, 2012 онд 523,3 тэрбум төгрөг, 2013 онд 520,4 тэрбум төгрөг, 2014 онд 462,0 тэрбум төгрөг төлж, 2 талын хувьцаа эзэмшигчдэд цэвэр ашгийнхаа 70 гаруй хувийг хуваарилж байсан боловч Компаний санхүүгийн байдал жилээс жилд хүндэрч үйлдвэрлэлийн өргөтгөл, шинэчлэлийн асуудал, хэрэгжүүлж буй төслүүд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсгэвэргүйн улмаас санхүүжилт нь дутуу хийгдэж, хойшилж он дамжсаар тэдгээрээс өгөх үр ашиг ч удааширч байна.

Компаний санхүүгийн байдал муудаж байгаа шалтгаануудын нэг нь “Ашигт малмалын тухай хууль”-ын 47-р зүйлийн дагуу борлуулалтын орлогоос шууд тооцдог байсан үнэлгээг, борлуулалтыг металаас тооцох болсон шинэ аргачлалтай болсоноор уул уурхайн үйлдвэрүүд татварын дарамтад орох болсон юм.

Ягаад буруу гэхээр үйлдвэрлээгүй борлуулаагүй бүтээгдэхүүнд татвар ноогдуулдаг жишиг дэлхийн аль ч улс оронд байхгүй ба мөн нэг ажил үйлчилгээнд давхар татварын систем үйлчилдэггүй зүй тогтолтой байтал манай АМНАТ-т татварын гурван нөхцөл, давхар татварын систем үйлчилж байна. Тэгээд ч аргачлал нэрээр хуулиар тогтоосон тоо хэмжээг өөрчилж байж таарахгүй.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2011-2014 онуудад үйлдвэрлээгүй, борлуулаагүй бүтээгдэхүүнд 164,3 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна (Хавсралт 1) . Зөвхөн 2014 онд 48,8 тэрбум төгрөг илүү төлсөн нь цэвэр металл зэсээр тооцсон дүнд, үйлдвэрийн бодитоор борлуулаагүй бүтээгдэхүүний үнийн дүн 16,8 хувийг, бодит борлуулалтын үнийн дүнд 20,7 хувь болж бараг 4 хувиар зөрүү гарч байна. (Хавсралт 2)

“Эрдэнэт үйлдвэр” ХХК ийн татвар төлж буй байдлыг улсын төсөвт АМНАТ төлж байгаа нь алт олборлогчтой харьцуулахад 8 дахин, “Оюу толгой” ХХК-тай харьцуулахад 3 дахин өндөр хураамж болж байна. Үүнээс дүгнэлт хийж үзвэл Ашигт малтмалын тухай

хуулийн дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт төлж байгаа байдал нь тэгш бус, зөвхөн 1 компанид үйлчилж байгааг харуулж байгаагийн зэрэгцээ борлуулаагүй бүтээгдэхүүнд татвар төлж, татварын дарамт үүсгэн, энэ байдал нь хуримтлагдаж төлбөрийн чадваргүй байдалд хүргэж байна.

Одоогийн байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 376 орчим сая ам.долларын буюу нийт борлуулалтын орлогын 50 хувьтай тэнцэх хэмжээний хуримтлагдсан өр, зээл, бэлэн мөнгөний хомсдолтой байна.

Мөн дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн тогтворгүй өнөө үед үйлдвэрийн уул геологийн нөхцөл хүндэрч, хүдэрт агуулагдаж буй зэсийн агуулга жилээс жилд буурч, чанар буурахын хирээр зардал өсч, ашигт ажиллагааны түвшин буурсаар байгаа нь бодит эрсдэлийг бий болгож байгаа юм.

Үүний учир цаашид Компаний санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээнүүд шаардлагатай ба татварын эрүүл орчин, татварын дэмжлэг төрийн зүгээс үзүүлэх нь нэн шаардлагатай болоод байгаа тул:

1. Дэлхийн бусад орнуудад Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн стандарт хэмжээ нь манай улсад мөрдөж байгаа Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй харьцуулахад хэдэн арван хувиас хэд дахин доогуур байгаа нь татварын хэмжээг эргэн харах үндсэн жишиг харьцуулалт болж байна. (Хавсралт 3)
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоос тооцдог байсан хуучин аргачлалдаа буцан орох
3. Ашигт малтмалын тухай хуулийн 47.4 дэх заалтад Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүтээгдэхүүн боловсруулалтын өөрийн өртөг нь тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнээс доогуур бол 47.2 дахь суурь төлбөрийг төлнө гэсэн нэмэлт оруулах
4. Дэлхийн зах зээл дээрх зэс болон бусад эрдсийн үнийн тогтворгүй үед уул уурхайн үйлдвэрүүдэд бодит эрсдэлийг бий болгож байдаг учир уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын 3% ийг үйлдвэрт үлдээж “Эрсдэлийн сан” байгуулах асуудлыг санаачилж шийдвэрлүүлэх зэрэг саналуудыг ажлын хэсэгт хүргүүлж байна.

Монгол Улсын ОУИТБС-ын ажлын хэсгийн гишүүн Д.Галбаатар

2015-03-23